



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

“Тэд-Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Ц.Сугармаа
Утас: 99151254 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com
Аудит менежер: В.Оюунчимэг
Утас: 99190483 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com
Ахлах аудитор: Н.Дэлгэрмаа
Утас: 99244686 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Тодм. 03.15 № 486
танай _____-ны № _____-т

ҮРТСЭН ШАХМАЛ ТҮЛШНИЙ
ҮЙЛДВЭР ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Х.ДАРАМБАЗАР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант жилд тус байгууллага нь үйл ажиллагаа явуулаагүй, тус үйлдвэрийг татан буулгах тухай Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/711 дугаар захирамж гарч Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ыг татан буулгасантай холбогдуулан өр, авлагын асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх"-ийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт даалгасан боловч шийдвэр гаргаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзэв.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,532.48	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,532.48	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	50,532.48	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	69,838,407.74	98,563,353.83
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	69,838,407.74	98,563,353.83
41361	Байгууллагад төлөх өглөг	17,884,937.00	25,533,207.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	10,041,726.00	26,553,323.78
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	36,124,363.74	36,181,547.98
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	5,787,381.00	10,295,275.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	50,532.48	-
51101	Өмч: - төрийн	2,519,405,515.00	2,519,405,515.00
512	Хуримтлагдсан ашиг	(2,589,193,390.26)	(2,617,968,868.83)
51210	Эздийн өмч	(69,787,875.26)	(98,563,353.83)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	50,532.48	-

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

МӨРИЙН ДУГААР	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Борлуулалтын орлого	51,665,227.27	-
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг	51,665,227.27	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	901,373,991.62	30,275,478.57
5	Ерөнхий ба удирдлагын зардал	866,835,966.01	30,275,478.57
6	Бусад зардал	34,538,025.61	
7	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(849,708,764.35)	-
8	Орлогын татварын зардал		
9	Татварын дараах ашиг, алдагдал	(849,708,764.35)	(30,275,478.57)
10	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(849,708,764.35)	(30,275,478.57)
11	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	(849,708,764.35)	(30,275,478.57)
12	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг	-	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	-
15	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(849,708,764.35)	(30,275,478.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	-

1.1.1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	50,532.48
1.2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,588,579.00	50,532.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	44,978,004.00	4,032.48
1.2.2	Нийгмийн даатгалд төлсөн	670,639.00	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	410,200.00	34,500.00
1.2.4	Ашиглалтын зардал	436,128.00	
1.2.5	Татварын байгууллагад төлсөн	81,908.00	
1.2.6	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	11,700.00	12,000.00
1.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	(50,532.48)
1.3.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	46,561,228.00	
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	46,561,228.00	-
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,351.00	(50,532.48)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,883.48	50,532.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,532.48	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дугаар	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,736,512,244.00	(1,445,359,471.33)	291,152,772.67
2	Дахин үнэлгээний нэмэгдэл	13,384.000.00		13,384.000.00
3	Өмчид гарсан өөрчлөлт	769,509,271.00	(1,143,833,918.93)	(374,324,647.93)
4	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,519,405,515.00	(2,589,193,390.26)	(69,787,875.26)
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	1,500,000.00	1,500,000.00
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,519,405,515.00	(2,587,693,390.26)	(68,287,875.26)
7	Тайлант үеийн үр дүн	-	(30,275,478.57)	(30,275,478.57)
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,519,405,515.00	(2,617,968,868.83)	(98,563,353.83)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Татан буулгах тухай шийдвэрийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	1	-			1	-		